



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/251-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Ц.Уртнасан
Утас: 70376994 Цахим хаяг: urtaa6969@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10-11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11-12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12-14
4. Аудитын тайлан	15-18
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15-16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16-17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17-18
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18-19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шитгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

АЛТАНБУЛАГ СУМЫН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.БОЛОРМАА ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/251/НА-СЭА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 12,493.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

018020247

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	<i>/төгрөгөөр/</i>	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,848,602.02	84,453,083.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,135,249.00	54,518,025.07
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,135,249.00	54,518,025.07
31210	Төгрөг	7,135,249.00	54,518,025.07
31211	Төрийн сангийн харилцах	7,135,249.00	54,518,025.07
35	БАРАА МАТЕРИАЛ	29,713,353.02	29,935,058.22
35400	Хангамжийн материал	29,713,353.02	29,935,058.22
35410	Бичиг хэргийн материал	150,000.00	0.00
35420	Аж ахуйн материал	27,887,661.02	29,935,058.22
35440	Түлш, шатах тослох материал	68,568.00	0.00
35460	Хүнсний материал	1,607,124.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	813,019,867.45	788,904,783.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	813,019,867.45	788,904,783.49
39200	Биет хөрөнгө	765,784,333.85	741,944,249.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	718,906,860.00	718,906,860.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(47927124.00)	(59908905.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	32,967,608.70	36,269,608.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13073975.04)	(21096503.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,691,175.94	21,691,175.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10788946.75)	(13593752.10)
39209	Зам, гүүрийн байгууламж	67,492,632.00	67,492,632.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(10770030.24)	(13462537.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,146,698.00	11,146,698.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4937478.76)	(6577940.92)
39217	Ном	1,076,914.00	1,076,914.00
39300	Биет бус хөрөнгө	47,235,533.60	46,960,533.68
39301	Программ хангамж	1,625,000.00	1,625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1016666.40)	(1291666.32)
39303	Бусад биет бус хөрөнгө	46,627,200.00	46,627,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	849,868,469.47	873,357,866.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	849,868,469.47	873,357,866.78
51	Засгийн газрын хувь оролцоо	849,868,469.47	873,357,866.78
51100	Засгийн газрын оруулсан капитал	106,812,733.82	106,812,733.82
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	106,812,733.82	106,812,733.82
51200	Хуримтлагдсан үр дүн	472,157,689.91	495,647,087.22
51210	Өмнөх үеийн үр дүн	(377710779.56)	472,157,689.91
51220	Тайлант үеийн үр дүн	849,868,469.47	23,489,397.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	270,898,045.74	270,898,045.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	849,868,469.47	873,357,866.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,389,413,822.88	677,183,933.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	860,559,452.88	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	860,559,452.88	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	834,652,691.86	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	25,906,761.02	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	528,854,370.00	677,183,933.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	451,336,200.00	594,624,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	451,336,200.00	594,624,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,518,170.00	82,559,633.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,518,170.00	82,559,633.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	539,545,353.41	653,694,536.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	539,545,353.41	653,694,536.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	539,545,353.41	645,573,936.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,017,613.00	416,788,870.08
210101	Үндсэн цалин	247,024,788.00	279,476,957.08
210102	Нэмэгдэл	82,200,092.00	117,000,327.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	20,792,733.00	20,311,586.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,658,633.00	58,767,546.00
210201	Тэтгэврийн даатгал	29,806,115.00	40,040,298.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,463,057.25	4,715,850.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,770,548.20	3,754,939.00
210204	Ажилгүйдлийн даатгал	692,513.05	932,126.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,926,399.50	9,324,333.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,671,145.00	79,089,633.50
210301	Гэрэл, цахилгаан	4,537,927.00	5,554,363.34
210302	Түлш, халаалт	35,596,888.00	63,038,630.16
210303	Цэвэр, бохир ус	10,536,330.00	10,496,640.00
2105	Нормативт зардал	42,334,706.00	46,056,444.00
210502	Хоол, хүнс	42,334,706.00	46,056,444.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,946,100.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	1,946,100.00	3,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.00	832,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	832,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,955,156.41	40,568,542.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,738,932.00	10,836,558.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,603,500.00	2,314,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,612,724.41	27,417,083.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,120,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	8,120,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	8,120,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	849,868,469.47	23,489,397.31
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	849,868,469.47	23,489,397.31

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		<i>/төгрөгөөр/</i>	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	528,854,370.00	677,183,933.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	528,854,370.00	677,183,933.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	451,336,200.00	594,624,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	451,336,200.00	594,624,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,518,170.00	82,559,633.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,518,170.00	82,559,633.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	516,739,221.00	626,499,157.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	516,739,221.00	626,499,157.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	506,164,721.00	618,378,557.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,417,613.00	416,788,870.08
210101	Үндсэн цалин	247,424,788.00	279,476,957.08
210102	Нэмэгдэл	82,200,092.00	117,000,327.00
210104	Урамшуулал	20,792,733.00	20,311,586.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,258,633.00	58,767,546.00
210201	Тэтгэврийн даатгал	29,406,115.00	40,040,298.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,463,057.25	4,715,850.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,770,548.20	3,754,939.00
210204	Ажилгүйдлийн даатгал	692,513.05	932,126.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,926,399.50	9,324,333.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,671,145.00	79,089,633.50
210301	Гэрэл, цахилгаан	4,537,927.00	5,554,363.34
210302	Түлш, халаалт	35,596,888.00	63,038,630.16
210303	Цэвэр, бохир ус	10,536,330.00	10,496,640.00
2105	Нормативт зардал	43,941,830.00	44,449,320.00
210502	Хоол, хүнс	43,941,830.00	44,449,320.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,946,100.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	1,946,100.00	3,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.00	832,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	832,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,967,400.00	14,980,287.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,467,400.00	12,481,587.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	2,498,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,574,500.00	8,120,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,574,500.00	8,120,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,574,500.00	8,120,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,115,149.00	50,684,776.07
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,979,900.00	3,302,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,979,900.00	3,302,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,979,900.00	3,302,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,979,900.00	3,302,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,979,900.00	-3,302,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	7,135,249.00	47,382,776.07
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	7,135,249.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,135,249.00	54,518,025.07

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	106,812,733.82	270,898,045.74	(377710779.56)	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	106,812,733.82	270,898,045.74	(377710779.56)	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	849,868,469.47	849,868,469.47
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	106,812,733.82	270,898,045.74	472,157,689.91	849,868,469.47
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	106,812,733.82	270,898,045.74	472,157,689.91	849,868,469.47
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	106,812,733.82	270,898,045.74	472,157,689.91	849,868,469.47
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	23,489,397.31	23,489,397.31
20	2023 оны 6-р сарын 30-нээрх үлдэгдэл	106,812,733.82	270,898,045.74	495,647,087.22	873,357,866.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	684,319,233.40	629,801,157.33	54,518,076.07	92.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	601,759,600.00	547,241,523.93	54,518,076.07	90.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	593,639,000.00	539,120,923.93	54,518,076.07	90.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,139,400.00	416,788,870.08	37,350,529.92	91.8
210101	Үндсэн цалин	294,780,100.00	279,476,957.08	15,303,142.92	94.8
210102	Нэмэгдэл	139,316,000.00	117,000,327.00	22,315,673.00	84.0
210104	Урамшуулал	20,043,300.00	20,311,586.00	-268,286.00	101.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,632,500.00	58,767,546.00	14,864,954.00	79.8
210201	Тэтгэврийн даатгал	50,070,200.00	40,040,298.00	10,029,902.00	80.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,890,700.00	4,715,850.00	1,174,850.00	80.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,712,300.00	3,754,939.00	957,361.00	79.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,178,400.00	932,126.00	246,274.00	79.1
210205	Эрүүл мэндийн даатгал	11,780,900.00	9,324,333.00	2,456,567.00	79.2
	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	79,089,633.40	79,089,633.40	0.00	80.2
210301	Гэрэл, цахилгаан	5,554,363.24	5,554,363.24	0.00	81.2
210302	Түлш, халаалт	63,038,630.16	63,038,630.16	0.00	82.2
210303	Цэвэр, бохир ус	10,496,640.00	10,496,640.00	0.00	83.2
	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00	0.00	84.2
210604	Урсгал зардал	3,470,000.00	3,470,000.00	0.00	85.2
2105	Нормативт зардал	46,744,300.00	44,449,320.00	2,294,980.00	95.1
210502	Хоол, хүнс	46,744,300.00	44,449,320.00	2,294,980.00	95.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	832,900.00	832,900.00	0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	832,900.00	832,900.00	0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,289,900.00	18,282,287.85	7,612.15	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,791,200.00	15,783,587.85	7,612.15	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,498,700.00	2,498,700.00	0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,120,600.00	8,120,600.00	0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,120,600.00	8,120,600.00	0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,120,600.00	8,120,600.00	0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	601,759,600.00	594,624,300.00	7,135,300.00	98.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	601,759,600.00	594,624,300.00	7,135,300.00	98.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	601,759,600.00	594,624,300.00	7,135,300.00	98.8

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,135,300.00	0		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	7,135,249.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	54,518,025.07		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхэд нэг бүрийн танин мэдэх хэрэгцээ сонирхолд нийцсэн ээлтэй орчин бүрдүүлж, тэдний бие даасан байдлыг дэмжих, тоглох явцдаа хамтдаа хөгжинө” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны зорилтуудаа дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийн эрүүл, аюулгүй, тэгш хүртээмжтэй сурч хөгжих, төвөлших боломжийг бүрдүүлж, сургалтын байгууллага-тоног төхөөрөмж арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан тасралтгүй хөгжих олон хэлбэрт сургалт үйл ажиллагааг зохион байгуулна,
- Багш ажилтан бүр “Ес зүйн” хэмжээ шаардлагыг мөрдөж, төсвийг төлөвлөх, үр ашигтай зарцуулахад оршино,
- Мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагаанд бүтээлчээр оролцож, Тэргүүлэх багшийн манлайлал үүрэг оролцоог нэмэгдүүлэх, чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Цэцэрлэгийн менежментийг сайжруулахад эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд шинэчлэгдэн батлагдсан
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд “1.ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, “2.Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн

талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,489.4 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,135.20	54,518.00	47,382.80
Авлага	-	-	-
Бараа материал	29,713.40	29,935.10	221.70
Үндсэн хөрөнгө	813,019.90	788,904.80	(24,115.10)
Нийт хөрөнгө	849,868.50	873,357.90	23,489.40
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	849,868.50	873,357.90	23,489.40
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	849,868.50	873,357.90	23,489.40

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 54,518.0 мянган төгрөг болж 47,382.8 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9¹-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 29,935.1 мянган төгрөг болж 221.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 56,865.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 56,643.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24,115.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 3,302.0 мянган төгрөгийн хөлдөөгч, гадна, дотор камер

¹ Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

худалдан авсан, тайлант онд 27,417.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 371,974.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 68,542.7 мянган төгрөг зэрэг нийт зарлагыг 440,517.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 56,044.2 мянган төгрөгөөр буюу цалин НДШ-ийн зардлыг 53,502.3 мянган төгрөгөөр, хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардлыг 2,541.9 нэмэгдүүлж нийт төсвийг 496,561.4 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 12 дугаар сард цалин хөлсийг 158,998.9 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 1,492.7 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урашууллын зардлыг 8,120.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 756.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 684,319.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 601,759.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 82,559.6 мянган төгрөг, нийт 684,319.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 629,801.1 мянган төгрөг буюу 92.0 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардлыг 52,215.5 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 2,295.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>							
Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,249.30	1,247.00	(2.30)	99.8
		2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	46,744.30	44,449.30	(2,295.00)	95.1

	3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,541.90	2,541.90	-	100.0
	4	81823-Боловсролын байгууллагын багш	1,249.30	1,244.00	(5.30)	99.6
	5	81834-Боловсролын стандарт сургалт	414,293.90	371,159.40	(43,134.50)	89.6
	6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	135,680.90	126,599.90	(9,081.00)	93.3
	7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	79,089.60	79,089.60	-	100.0
	8	80112-Нийтлэг үйлчилгээ	3,470.00	3,470.00	-	100.0
	Нийт		684,319.20	629,801.10	(54,518.00)	92.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	47,067.1	44,449.3	НТШ
	Нийт дүн	47,067.1	44,449.3	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад гүйцэтгэгчээр шалгарсан “Бумбат арвижих” ХХК-тай 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосонд хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Ц.Уртнасан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 539,545.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,395.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төсөв, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 2 удаа,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг 3 удаа.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.1, 6.4.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын байгууллагын 2023 оны 10 дугаар 26-ны өдрийн 123 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх

тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулалгүй худалдан авалт хийсэн зөрчлийг давтан гаргасантай холбоотой 2,637.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2,637.4	1	2,637.4	100
Нийт дүн	1	2,637.4	1	2,637.4	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй балансын урамшуулал гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Өмнөх онд албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал уг албан бичгийн дагуу тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт **1,982.0** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Н.Эрдэнэцэцэгт 1,114.0 мянган төгрөг,
- Нярав С.Алтанцэцэгт 868.0 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар нийт 544.3 мянган төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалж багш Н.Янжинсүрэнд 544.3 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг илүү тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Нягтлан бодогч нь дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Амралтын цалинг илүү тооцож олгосон.	1	544.3	1	544.3								



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 44/А1870392

Сүхбаатар

СГА-2024/251/НА-СГА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар багш Н.Янжинсүрэнд 544.3 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалин илүү бодож олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3: "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Илүү олгосон 544.3 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.
- Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Д.Болормаа, нягтлан бодогч Н.Эрдэнэцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТОР

Ц.УРТНАСАН

018050132

Албан шаардлага, төлбөрийн актын бүртгэл, хяналтын хуудас

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл хяналт

1. Үндсэн мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	СЭА-2024/251-НА-СТА-ТШЗ		
1.3 Аудит хийх үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит		
1.5 Албан шаардлага, төлбөрийн актын дугаар/А1870392 СЭА-2024/251-НА-СТА-ТШЗ	1.6 Тогтоосон огноо	2024.02.23	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	544,300.0

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Зөрчил дутагдлыг товч тодорхойлж бичих	багш Н.Янжинсүрэнд 544.3 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалин илүү бодож олгосон			
	Алдаа, зөрчлийн ангилал	Төлбөрийн акт			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	Журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль		
		Заалт	13.1, 20.2.5		
Нэр					
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хууль, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам",			
	Заалт	Хуулийн 21.2, журмын 4.2.3, 4.2.3.3,			

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд		544,300.0	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд			
	Тухайн байгууллагын дансанд			
				2023.06.15

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
2	Цалингийн баримт,		2023 он	

3 Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

Аудитын багийн		Хариуцагч			
Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих утас
Ц.Уртнасан	Аудитор	Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэг	Эрхлэгч	Д.Болормаа	99072507
			Нягтлан бодогч	Н.Эрдэнэцэцэг	99286504

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал, зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер			
2	Тэргүүлэх аудитор			

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор			

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо	
		Дугаар	

2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо		2024.02.23.
		Ажилтны	Овог нэр	Ц.Уртнасан
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр		Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэг
		Ажилтны	Овог нэр	Н.Эрдэнэцэцэг
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Байгууллагын нэр		Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар
		Ажилтны	Овог нэр	Ц.Уртнасан
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөж		